

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2026/002-НА-СТА-ТӨА

Цахим хуудас:
www.audit.mn
Алтай хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Цэрэнханд, Б, Цэцэгмаа, М.Атарцэцэг
Утас: 99086371, 99041524, 88984411
Цахим хаяг: govialtai@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
4. Аудитын тайлан.....	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	13
4.4.3 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	14
4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. Аудитын илрүүлэлт	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ААҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
УЦС	Усан цахилгаан станц



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.03.15 № 132

танай _____ -ны № _____ -т

АЛТАЙ-УЛИАСТАЙН ЦАХИЛГААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.ЦЭДЭВСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Алтай-Улиастайн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Засгийн газрын “Эрчим хүчний салбарын төрийн өмчит зарим компанийн талаар авах арга хэмжээний тухай” 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 30 дугаар тогтоолоор тус компанийг Алтай-Улиастайн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Тайшир-Ногоон эрчим ТӨХК болгон өөрчлөн байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 13 дугаар тогтоолоор компанийн 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

822511000398

Тогтоолоор борлуулалтын орлогыг 30,009,700.1 мянган төгрөгөөр, үндсэн бус үйл ажиллагааны орлогыг 3,383,000.0 мянган төгрөгөөр, улсын төсвийн татаас санхүүжилтийг 2,200,000.0 мянган төгрөгөөр, нийт орлогыг 35,592,700.1 мянган төгрөгөөр, нийт зардлыг 34,519,100.0 мянган төгрөгөөр төлөвлөж, 1,073,600.1 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөгөөг баталсан байна.

Гүйцэтгэлээр борлуулалтын орлого 30,551,041.1 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 284,391.7 мянган төгрөг, улсын төсвийн татаас санхүүжилт 1,909,090.9 мянган төгрөг, нийт орлого 32,744,523.7 мянган төгрөгийн орлого төвлөрч, 30,862,008.6 мянган төгрөгийн зардал гарган, 1,882,515.1 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Тайлант оны зардлыг 3,657,091.4 мянган төгрөгөөр хэмнэсэн нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан 6 ажлын 4,372,069.4 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаа амжилтгүй болж, зардал гаргаагүйтэй холбоотой байна.

Бусад асуудал

Тайлант онд 7 зорилтын хүрээнд 94 арга хэмжээг хэрэгжүүлэхээр үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг 93.0 хувиар тооцож үнэлсэн бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцээгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		2025 оны 1 сарын 1	2025 оны 12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,876,945,922.36	5,466,658,125.36
1.1.02	Дансны авлага	651,241,943.77	1,658,174,809.84
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	25,304,777.85	9,113,055.05
1.1.04	Бусад авлага	3,602,792.00	3,602,792.00
1.1.06	Бараа материал	2,065,078,429.91	2,344,868,038.29
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	406,172,851.01	1,164,366,271.05
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	7,028,346,716.90	10,646,783,091.59
1.2.01	Үндсэн хөрөнгө	88,382,116,502.11	100,553,158,220.29
1.2.02	Биет бус хөрөнгө	5,203,747,550.49	3,800,124,750.85
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	93,585,864,052.60	104,353,282,971.14
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	100,614,210,769.50	115,000,066,062.73
2.1.1.01	Дансны өглөг	36,294,432.52	65,085,190.49
2.1.1.03	Татварын өр	503,183,936.44	936,008,234.15
2.1.1.04	НДШ - ийн өглөг	67,925.00	0.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	52,484,782.52	56,438,434.09
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	592,031,076.48	1,057,531,858.73
2.1.2.01	Урт хугацаат зээл	42,805,500,266.42	42,805,500,266.42
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	42,805,500,266.42	42,805,500,266.42
2.2	Өр төлбөрийн нийт дүн	43,397,531,342.90	43,863,032,125.15
2.3.02	- төрийн	60,388,037,164.58	60,388,037,164.58
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,766,759,566.66	5,766,759,566.66
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	30,141,669,485.41	42,219,732,960.17
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-	(37,237,495,753.83)
		39,079,786,790.05	
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	1,882,515,132.37
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-	(39,120,010,886.20)
		39,079,786,790.05	
2.3.11	Эздийн өмчийн дүн	57,216,679,426.60	71,137,033,937.58
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	100,614,210,769.50	115,000,066,062.73

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Мөрийн дугаар	Балансын зүйл	2025 оны 1 сарын 1	2025 оны 12 сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	22,848,068,050.41	33,305,120,041.36
02	Борлуулалтын өртөг	21,787,880,749.54	24,324,097,317.65
03	Нийт ашиг(алдагдал)	1,060,187,300.87	8,981,022,723.71

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

04	Түрээсийн орлого	6,760,000.00	10,950,000.00
05	Хүүний орлого	40,573,352.62	60,908,301.80
08	Бусад орлого	5,719,926,580.07	2,140,334,184.84
08.1	Орлогын дүн	5,767,259,932.69	2,212,192,486.64
09	Борлуулалт, маркетингийн зардал	1,583,964,559.79	2,211,097,691.45
10	Ерөнхий ба удирдлагын зардал	4,551,879,026.12	5,961,041,118.98
12	Бусад зардал	116,584,450.53	19,326,682.28
12.1	Зардлын дүн	6,252,428,036.44	8,191,465,492.71
17	Бусад ашиг (алдагдал)	-57,674,535.86	0.00
17.1	Олз, гарзын дүн	-57,674,535.86	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	517,344,661.26	3,001,749,717.64
19	Орлогын татварын зардал	388,133,822.02	1,119,234,585.27
20	Татварын дараах ашиг (алдагдал)	129,210,839.24	1,882,515,132.37
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	129,210,839.24	1,882,515,132.37

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2025 оны 1 сарын 1	2025 оны 12 сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	20,014,617,848.98	62,166,107,567.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	17,066,776,193.61	38,063,131,496.53
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	10,864,235.90	15,805,862.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	2,394,975,809.08	2,100,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	542,001,610.39	21,987,170,208.47
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	18,977,268,163.10	56,888,383,666.53
1.2.1	Ажиллагчдад төлсөн	4,011,924,013.09	13,451,117,939.98
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,238,325,901.13	2,869,352,280.45
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	8,352,317,938.52	6,789,018,449.03
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	62,990,352.77	155,614,828.90
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,007,071,922.47	930,490,815.90
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	1,103,848.60
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,164,819,631.40	4,017,442,206.45
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	28,385,552.00	27,050,554.35
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,111,432,851.72	28,647,192,742.87
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,037,349,685.88	5,277,723,900.47
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	79,317,479.81	52,253,684.13
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	3,159.81	52,253,684.13
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	17,000,000.00	3,740,265,381.60
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	17,000,000.00	3,740,265,381.60
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	62,317,479.81	(3,688,011,697.47)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,099,667,165.69	1,589,712,203.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	25,914,304.86	3,876,945,922.36
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,876,945,922.36	5,466,658,125.36


 4

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	60,388,037,164.58	5,766,759,566.66	28,300,571,307.24	(39,157,888,337.60)	55,297,479,700.88
2	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(51,109,291.69)	(51,109,291.69)
3	Залруулсан үлдэгдэл	60,388,037,164.58	5,766,759,566.66	28,300,571,307.24	(39,208,997,629.29)	55,246,370,409.19
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	129,210,839.24	129,210,839.24
6	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	1,841,098,178.17	-	1,841,098,178.17
9	2025 оны 01 сарын 31-ээр үлдэгдэл	60,388,037,164.58	5,766,759,566.66	30,141,669,485.41	(39,079,786,790.05)	57,216,679,426.60
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(40,224,096.15)	(40,224,096.15)
11	Залруулсан үлдэгдэл	60,388,037,164.58	5,766,759,566.66	30,141,669,485.41	(39,120,010,886.20)	57,176,455,330.45
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,882,515,132.37	1,882,515,132.37
14	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	12,078,063,474.76	-	12,078,063,474.76
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	60,388,037,164.58	5,766,759,566.66	42,219,732,960.17	(37,237,495,753.83)	71,137,033,937.58

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

НЭГТГЭЛ		НЭГТГЭЛ		ХЭТРЭЛТ - ХЭМНЭЛТ+
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО		30,009,700.1	30,551,041.1	541,341.0
1	Энергийн тарифаар	25,775,279.31	29,655,191.53	3,879,912.22
2	Чадлын тарифаар	2,736,419.01	-	(2,736,419.01)
3	Суурь хураамжаар	1,498,001.80	895,849.60	(602,152.20)
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		30,344,235.7	29,742,859.3	(601,376.4)
1	Түлшний зардал	134,865.7	68,587.50	(66,278.2)
2	Усны зардал	5,738.2	8,775.36	3,037.2
3	Худалдан авсан ЦЭХ зардал	4,330,900.0	4,401,935.7	71,035.7

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

4	Түүхий эд материалын зардал	59,486.4	57,817.02	(1,669.4)
5	Шатахууны зардал	286,969.5	276,109.23	(10,860.3)
6	Тээврийн зардал	44,172.6	12,573.82	(31,598.8)
7	Сэлбэг хэрэгсэл	542,513.9	516,612.11	(25,901.8)
8	Урсгал засвар	424,693.7	295,705.84	(128,987.8)
9	Материал, хангамжийн материал	156,693.5	103,334.49	(53,359.1)
10	үндсэн ба нэмэгдэл цалин урамшуулал	13,346,156.0	13,332,267.52	(13,888.5)
11	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	2,034,898.0	1,928,248.30	(106,649.7)
12	Ашиглалтын зардал-Цахилгаан	159,516.5	147,111.63	(12,404.9)
13	Ашиглалтын зардал-Дулаан	118,226.0	116,548.35	(1,677.7)
14	Ашиглалтын зардал-Ус	22,013.8	17,636.02	(4,377.8)
15	Албан томилолтын зардал	159,936.5	156,175.54	(3,760.9)
17	Контор хангамжийн зардал	50,189.8	26,582.05	(23,607.8)
18	Харилцаа холбооны зардал	58,660.8	55,328.25	(3,332.6)
19	Харуул хамгаалалтын зардал	84,720.0	79,604.82	(5,115.2)
20	Хөдөлмөр хамгааллын зардал	400,541.9	325,401.79	(75,140.1)
21	Даатгалын зардал	39,715.9	34,944.74	(4,771.1)
22	Байгаль орчин хамгаалах зардал	79,167.5	72,347.77	(6,819.7)
23	Галын аюулаас хамгаалах зардал	23,975.1	18,451.52	(5,523.6)
24	Удирдлагын зардал	943,792.0	876,550.0	(67,242.0)
	үндсэн ба нэмэгдэл цалин	690,435.0	674,048.81	(16,386.2)
	Цалингийн шимтгэл	105,822.6	89,958.59	(15,864.0)
	Томилолт	53,054.5	51,212.34	(1,842.1)
	Шатахууны зардал	66,097.7	48,217.08	(17,880.6)
	Холбоо	6,586.0	3,033.84	(3,552.2)
	Бичиг хэрэг	8,526.2	6,629.31	(1,896.9)
	Сургалт	350.0	-	(350.0)
	Удирдлагын бусад	12,920.0	3,450.00	(9,470.0)
25	Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал	162,624.0	141,792.17	(20,831.8)
27	Борлуулалт маркетингийн зардал	274,308.7	229,219.33	(45,089.4)
29	Зохицуулалтын үйлчилгээний хөлс	100,278.0	93,610.73	(6,667.3)
30	Гаднын үйлчилгээний хөлс	173,192.0	222,325.39	49,133.4

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

32	Сургалт	88,929.2	78,042.77	(10,886.4)
33	үйл ажиллагааны бусад зардал	-	153,428.84	153,428.8
34	Элэгдэл	4,358,799.8	4,316,452.81	(42,347.0)
35	Орлогын албан татвараас бусад татварын дүн	395,616.3	373,263.0	(22,353.3)
36	Үл хөдлөх хөрөнгийн татвар	261,190.2	255,387.64	(5,802.5)
37	АТӨЯХ-ийн албан татвар	3,615.6	2,184.83	(1,430.7)
38	Газрын төлбөр	92,332.1	81,205.80	(11,126.3)
39	Бусад хураамж	38,478.5	34,484.73	(3,993.8)
40	Ажиллагсдын нийгмийн зардал	1,282,944.3	1,206,074.9	(76,869.4)
	Ажиллагсадын хоолны хөнгөлөлт	574,883.3	527,319.49	(47,563.8)
	Ажиллагсадын түлшний хөнгөлөлт	92,250.0	79,715.31	(12,534.7)
	Ажиллагсадын түлшний хөнгөлөлт /ахмадууд/	55,500.0	53,262.00	(2,238.0)
	ЭХ тэргүүний ажилтны урамшуулал	27,735.0	25,440.00	(2,295.0)
	Ажиллагсдад олгох тусламж, буцалтгүй тусламж	98,616.0	101,022.08	2,406.1
	Тэтгэмж	340,527.0	333,169.85	(7,357.2)
	Эрүүл мэндийн үзлэг, эмчилгээ, сувилгааны зардал	56,575.0	54,964.78	(1,610.2)
	Ажиллагсдад олгосон шагнал урамшуулал	28,858.0	31,181.35	2,323.4
	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ АЛДАГДАЛ:	(334,535.5)	808,181.9	1,142,717.4
	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН:	5,583,000.0	2,193,482.6	(3,389,517.4)
42	Улсын төсвийн санхүүжилтын орлого	2,200,000.0	1,909,090.91	(290,909.1)
43	Хүүгийн орлого	11,999.9	60,905.43	48,905.5
44	Харуулын постын орлого	10,000.0	2,736.69	(7,263.3)
45	Алдангийн орлого	-	-	-
46	Төлбөрт ажил үйлчилгээний орлого/Техникийн нөхцөл	135,580.7	220,749.57	85,168.9
48	Бусад орлого	3,225,419.4	-	(3,225,419.4)
	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН:	4,174,864.4	1,119,149.3	(3,055,715.0)
50	Хүүгийн зардал-Богино хугацаат зээл	979,364.4	-	(979,364.4)
51	үйл ажиллагааны бусад зардал	3,195,500.0	1,119,149.35	(2,076,350.7)
	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ АЛДАГДАЛ:	1,408,135.6	1,074,333.2	(333,802.4)
	НИЙТ ОРЛОГО:	35,592,700.1	32,744,523.7	(2,848,176.4)
	НИЙТ ЗАРДАЛ:	34,519,100.0	30,862,008.6	(3,657,091.4)
	НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)	1,073,600.1	1,882,515.1	808,915.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компанийн, түүний үйл ажиллагаа

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК нь Говь-Алтай, Завхан аймгийн хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэглээг хосолмол эх үүсвэрээр тогтвортой хангах зорилт тавин ажилладаг.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, хуваарилах үйл ажиллагаа, цахилгаан эрчим хүчээр зохицуулалттай хангах, цахилгаан эрчим хүчний шугамын болон тоног төхөөрөмжийн ашиглалт, угсралт, засвар үйлчилгээг үзүүлэх гэж тодорхойлжээ.

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК нь Засгийн газрын 2008 оны 233 дугаар тогтоолоор байгуулагдсан.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 30 дугаар тогтоол “Эрчим хүчний салбарын төрийн өмчит зарим компанийн талаар авах арга хэмжээний тухай”-оор Алтай-Улиастайн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Тайшир-Ногоон эрчим ТӨХК болгон 2 хувааж өөрчлөн байгуулсан байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Төрийн өмчийн оролцооны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн тухайн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийг төлөөх гишүүний нэрийг төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд тухайн компанийн нэр дэвшүүлэх хороонд санал болгох” гэж заасны дагуу компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хувьцаа эзэмшигчид томилж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн 18 дугаар тогтоол “Эргэлтийн болон үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай”,
- Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн 19 дүгээр тогтоол “Бүртгэлгүй хөрөнгө шилжүүлэх тухай”,
- Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 27 дүгээр тогтоол “Бүтэц орон тоо батлах тухай”,
- Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01 дүгээр тогтоол “Бүтэц орон тоо батлах тухай”,
- Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 07 дугаар тогтоол " Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай",
- Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 13 дугаар тогтоол "Компанийн 2025 оны техnid, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвний төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай"

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Үүнд:

- Тайлант онд 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд 3 төрлөөр, дотоод хяналт хийж, 674,906.9 мянган төгрөгийн зөрчил илрүүлэн 58 зөвлөмж хүргүүлж нийт дүнгээр 79.0 хувийн хэрэгжилттэйгээр тайлагнасан,
- Компанийн худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөний явц, гүйцэтгэл, үр ашигт дотоод аудит хийж, 5 зөвлөмжийг хүргүүлсэн ба биелэлтийг бүрэн хангуулсан,
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2025 оны 01-11 дүгээр сарын байдлаар хамруулан, 9 зөвлөмж хүргүүлснийг 64.0 хувьтай хангуулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, тусгай зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2016 онд баталсан бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарт, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14.0 хувиар буюу 14,385,855.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,876,945.9	5,466,658.1	1,589,712.2
Авлага	680,149.5	1,670,890.7	990,741.1
Бараа материал	2,065,078.4	2,344,868.0	279,789.6
Урьдчилж төлсөн зардал	406,172.9	1,164,366.3	758,193.4
Үндсэн хөрөнгө	93,585,864.1	104,353,283.0	10,767,418.9
Нийт хөрөнгө	100,614,210.8	115,000,066.1	14,385,855.3
Өр төлбөр	43,397,531.3	43,863,032.1	465,500.8
Өмч	57,216,679.4	71,137,033.9	13,920,354.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	100,614,210.8	115,000,066.1	14,385,855.3

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Тухайлбал:

Банкин дахь харилцах дансны үлдэгдэл 5,466,658.1 мянган төгрөг болж, 1,589,712.2 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөт ажлууд он дамжин хэрэгжиж байгаатай холбоотой байна.

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,670,890.7 мянган төгрөг болж, 990,741.1 мянган төгрөгөөр өссөн нь цахилгааны авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Томоохон аж ахуй нэгжээс авах цахилгааны авлага нэмэгдсэнтэй холбоотой байна. Тухайлбал: Ундарга-Алтай ААТҮГ, Мандал голомт ХХК,

Бараа материалын дансны үлдэгдэл 2,344,868.0 мянган төгрөг болж, 279,789.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд 4,112,594.9 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж, үйл ажиллагаандаа 3,755,586.7 мянган төгрөгийн материалыг зарцуулсан ба 24,498.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй бараа материалыг шилжүүлж, гүйцэтгэх захирлын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/123 дугаар тушаалаар 21,207.1 мянган төгрөгийг Цахилгаан дамжуулах Үндэсний сүлжээ ТӨХК-д шилжүүлж, 87,257.9 мянган төгрөгийн аюулгүй нөөцийг Завхан салбар, Тайшир Гуулин ХХК-д шилжүүлсэн байна.

Тайлант онд гүйцэтгэх захирлын 2025 оны 07 дугаар сарын 07-ны А/87 дугаар тушаалаар 56,653.6 мянган төгрөгийн, 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар 38,014.1 мянган төгрөгийг, 12 дугаар сарын 30-ны А/124 дүгээр тушаалаар 41,939.9 мянган төгрөгийн нийт 136,607.6 мянган төгрөгийн бараа материалыг акталж устган, устгалын акт үйлдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 104,353.3 мянган төгрөг болж, 10,767.4 мянган төгрөгөөр өсжээ.

Тайлант онд 3,113,131.7 мянган төгрөгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 2,477,972.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй бүртгэн, 2,374,324.2 мянган төгрөгийн хөрөнгийг Завхан салбар Цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК-д шилжүүлж, аймгийн Засаг даргын захирамжаар хүчингүй болгосон 2,000,248.0 мянган төгрөгийн Сэрвэнгийн нарны станцын газрыг данснаас хассан байна. Тайлант онд акталж устгасан үндсэн хөрөнгө байхгүй.

Тайшир ногоон эрчим хүч компанид 82,272,963.3 мянган төгрөгийн балансын үнэтэй, 18,701,438.9 мянган төгрөгийн элэгдэлтэй, 63,571,524.4 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийн шилжүүлэх саналыг боловсруулж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон Эрчим хүчний яаманд хүргүүлсэн бөгөөд шийдвэр гараагүй байна.

Өглөг дансанд 43,863.032.7 мянган төгрөг болж, 465,500.8 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд ашигтай ажилласнаар Татварын газарт 962,350.6 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөр үүссэн байна.

Тайширын усан цахилгаан станцын төслийг хэрэгжүүлэхэд Монгол Улс, Араб Эдийн Засгийн Хөгжлийн Кубейтын сан, Абу-Дабигийн хөгжлийн сангаас 42,805,500.3 мянган төгрөгийн гадаад зээлийг 2011 онд авч ашиглалтад оруулсан боловч 2012 оноос хойш дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулаагүй, төлөөгүй үлдэгдлээр байна.

Өмчийн дансны үлдэгдэл 71,137,033.9 мянган төгрөг болж, 13,920,354.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны санхүүгийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу тус газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 13 дугаар тогтоол "Компанийн 2025 оны техnid, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвний төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай"-оор шинэчлэн баталсан байна.

Тогтоолоор борлуулалтын орлогыг 30,009,700.1 мянган төгрөгөөр, үндсэн бус үйл ажиллагааны орлогыг 3,383,000.0 мянган төгрөгөөр, улсын төсвийн татаас санхүүжилтийг 2,200,000.0 мянган төгрөгөөр, нийт орлогыг 35,592,700.1 мянган төгрөгөөр, нийт зардлыг 34,519,100.0 мянган төгрөгөөр төлөвлөж, 1,073,600.1 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөгөөг баталсан байна.

Гүйцэтгэлээр борлуулалтын орлого 30,551,041.1 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 284,391.7 мянган төгрөг, улсын төсвийн татаас санхүүжилт 1,909,090.9 мянган төгрөг, нийт орлого 32,744,523.7 мянган төгрөгийн орлого төвлөрч, 30,862,008.6 мянган төгрөгийн зардал гарган, 1,882,515.1 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 32,744,523.7 мянган төгрөг болж төлөвлөснөөс 2,848,176.4 мянган төгрөг буюу 8.0 хувиар тасарсан нь борлуулалтын орлого 541,341.0 мянган төгрөгөөр давж, үндсэн бус үйл ажиллагааны орлого 3,389,517.4 мянган төгрөгөөр тасарсантай холбоотой байна. Шалтгаан нь Эрчим хүчний яамнаас уг орлогыг тодорхой бус арга хэмжээнд баталж өгсөн бөгөөд компаниас уг орлоготой холбоотой санал өгөөгүй байна.

Борлуулалтын орлого 541,341.0 мянган төгрөгөөр давсан нь Хан-Алтай ХХК, Цэн газар ХХК-ны цахилгаан эрчим хүчний хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл 30,862,008.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 3,657,091.4 мянган төгрөг буюу 11.0 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан 6 ажил он дамжин хийгдсэнтэй холбоотой байна.

Компанийн худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд 64 ажлыг 8,921,611.0 мянган төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан боловч гүйцэтгэлээр 58 ажлыг 4,549,541.6 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулсан нь нийт санхүүжилтийн 51.0 хувийг эзэлж байна.

Батлагдсан зорилтот түвшний биелэлт, хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2026 оны 3 дугаар сарын 09-ний өдрөөс 2025 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хооронд ахлах аудитор Д.Цэрэнханд, М.Атарцэцэг, Б.Цэцэгмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 55 дугаартай албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан үйлдвэр санхүүжилтийн төлөвлөгөөний нийт зарлагын дүнгээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны үйлдвэр санхүүжилтийн төлөвлөгөөний нийт зардал 35,151,700.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 527,275.5 мянган төгрөгөөр тогтоосныг дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

Мөн санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75.0 хувь буюу 395,456.6 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шалгагдагч байгууллага нь дараах зөрчлийг гаргасан байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн хууль зөрчин албан хаагчдад шагнал, тэтгэмж, бусад зардалд 52,345.0 мянган төгрөгийг зарцуулсан,
- Олон нийтэд эрчим хүчний үнэ салбарын мэдээллийг олон нийтэд сурталчлах зорилгоор шилжүүлж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй арга хэмжээнд 99,800.0 мянган төгрөгийг зарцуулсан,
- Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 27 дүгээр тогтоол “Бүтэц орон тоо батлах тухай”-оор 370 байхаар өмнөх оноос 2 орон тоог /ил тод байдал маркетинг хариуцсан менежер, гүйцэтгэлийн үнэлгээ дотоод хяналт хариуцсан менежер/ нэмж баталсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасны дагуу Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, төлбөрийн баримтын бүрдэл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод хяналт хийж, дутуу мэдээлсэн шийдвэрүүдийг нөхөн 12 дугаар сард мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалттай нийцэхгүй байна.

Шилэн дансны цахим системд мэдээлбэл зохих 163,255,159.6 мянган төгрөгийн 1,785 мэдээллээс, 4,305,401.5 мянган төгрөгийн 240 мэдээллийг мэдээлээгүй байсныг аудитаар нөхөн мэдээлүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Тайлант онд компаниуд нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, зардлуудын худалдан авалт хийхдээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй 356,934.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Босго үнээс давсан арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулан, зохион байгуулах зөвлөмжийг компаниудад хүргүүлсэн.

2. Алтай-Улиастай ЭХС ТӨХК-нь олон нийт хэвлэл мэдээлэлийн ажилтны нэр дээр бүртгэлтэй Миний алтай ХХК-тай гэрээ байгуулж, 19,900.0 мянган төгрөгийг шилжүүлсэн нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Алтай-Улиастай ЭХС ТӨХК-ийн ТУЗ-өөс компанийн худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд 64 ажлыг 8,921,611.0 мянган төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан боловч гүйцэтгэлээр 58 ажлын 4,549,541.6 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулсан нь нийт санхүүжилтийн 51.0 хувийг эзэлж байна.

4. Алтай-Улиастай ЭХС ТӨХК нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй ариун цэврийн өрөөний засварын зардал 19,000.0 мянган төгрөгийг Борх бэхи ХХК-д, борлуулалтын өрөөний засвар, бусад засварын зардалд 35,500.0 мянган төгрөгийг Эсан ХХК-д, геодезийн зураг, зураг төсөв хийлгэхэд 28,662.2 мянган төгрөгийг Шугам ХХК-д шилжүүлж, хөрөнгө бэлтгэсэн.

5. Алтай-Улиастай ЭХС ТӨХК нь Алаг царам ХХК-аас 06 дугаар сард 5 удаагийн нийт 83,980.5 мянган төгрөгийн эрчим хүчний тоног төхөөрөмж, материал худалдан авах шууд авах гэрээ байгуулсан зэрэг зөрчил илэрсэн нь Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2012 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан "Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн дүрэм"-ын 7.13.6-д "гүйцэтгэх удирдлагын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг үр ашигтай зохион байгуулахад хяналт тавьж ажиллах", Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн 17 дугаар "Компанийн худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тогтоолтой нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлөөлөн Удирдах зөвлөлийн хараат бус гишүүдэд худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

4.4.3 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 257,588.4 мянган төгрөгийн зөрчил арилгах 17 албан шаардлага, 16,548.5 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 22,759.4 мянган төгрөгийн 11 төлбөрийн акт тогтоосныг хэрэгжүүлж, 5,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй 98.3 хувьтай байна.

Хүснэгт 3: Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөг)

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	12	257,588.4	11	252,588.4	1	5,000.0	98.1
Зөвлөмж	3	16,548.5	3	16,548.5	0	-	100.0
Төлбөрийн акт	11	22,759.4	11	22,759.4	0	-	100.0
Нийт дүн	26	296,896.3	25	291,896.3	1	5,000.0	98.3

4.5 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татах дараах асуудлууд байна.

- Тайширын усан цахилгаан станцын төслийг хэрэгжүүлэхэд Монгол Улс, Араб Эдийн Засгийн Хөгжлийн Кубейтын сан, Абу-Дабигийн хөгжлийн сангаас 42,805,500.3 мянган төгрөгийн гадаад зээлийг авч ашиглалтад оруулсан боловч 2012 оноос хойш дамжуулан зээлдүүлэх гэрээг байгуулаагүй, төлөх эх үүсвэр байхгүйгээс төлбөрийг төлөөгүй, данс бүртгэлд хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөр бүртгэлтэй байгааг анхаарч үзэх.
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй арга хэмжээг санхүүжүүлсэн, төсөвт өртгийг хуваан шууд худалдан авалт хийсэн асуудлыг үзэх.
- Компанийн зорилтот түвшний биелэлтийг үндэслэлтэй төлөвлөж баталж байх

5. Аудитын илрүүлэлт

5.1 Аудитаар илэрсэн 5,040,671.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын 10 алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Тосонцэнгэл УЦС ХХК 18,709.9 мянган төгрөгөөр, Богдын голын УЦС 1,674.9 мянган төгрөгөөр мөнгөн гүйлгээний тайлангийн орлогыг зөрүүтэй тайлагнасан,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Тосонцэнгэл УЦС ХХК 17,440.4 мянган төгрөгөөр мөнгөн гүйлгээний тайлангийн зардлыг зөрүүтэй тайлагнасан,
- Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК 466,578.6 мянган төгрөгөөр орлого үр дүнгийн тайлангийн борлуулалтын орлогыг зөрүүтэй тайлагнасан,
- Богдын голын УЦС ХХК 1,211.4 мянган төгрөгөөр орлого үр дүнгийн тайлангийн зардлыг зөрүүтэй тайлагнасан,
- Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК 119,985.2 мянган төгрөгийн шилжүүлсэн бараа материалыг бусад ангилалд тайлагнасан,
- Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК 109,669.3 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөрийг илүү тайлагнасаныг залрууллаа.

Мэдээллийг орхигдуулсантай холбоотой:

- Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 73,520,787.7 мянган төгрөгийн 741 мэдээллээс, 6 тендер худалдан авах ажиллагаатай холбоотой 3,948,537.2 мянган төгрөгийн мэдээлэл, өмч хөрөнгө зарцуулалтай холбоотой 38 шийдвэрийг мэдээлээгүй,
- Богдын гол УЦС ХХК нь шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр хэсэгт мэдээлбэл зохих 188,326.3 мянган төгрөгийн 65 мэдээлэл мэдээлээгүй
- Тосонцэнгэл УЦС ХХК нь шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр хэсэгт мэдээлбэл зохих 168,538.0 мянган төгрөгийн 131 мэдээлэл мэдээлээгүйг нөхөн байршуулсан.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй байсан мэдээллүүдийг нөхөн мэдээлүүлсэн.

Залруулагдаагүй нийт 980,414.3 мянган төгрөгийн зөрчлөөс санхүүгийн асуудалтай холбоото 436,437.0 мянган төгрөгийн, нийцлийн асуудалтай холбоотой 543,978.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Санхүүгийн асуудалтай холбоотой 436,437.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 980,414.3 мянган төгрөгийн 25 зөрчил² илэрсэнд, 2,542.5 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 200,374.0 мянган төгрөгийн зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 6 албан шаардлага, 777,498.0 мянган төгрөгийн 14 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн нийцлийн асуудалтай холбоотой 524,078.0 мянган төгрөгийн 6 зөвлөмж, 19,900.0 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг аудитын тайлангийн 4.4-т заасан санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал хэсэгт тусгасан.

Санхүүгийн асуудалтай холбоотой зөрчил:

5.2 Төлбөрийн акт

1. Тайшир Гуулин УЦС ХХК нь 12 сарын цагийн бүртгэлийг зөрүүтэй хөтөлснөөс Б.Түвшинжаргалд 944.5 мянган төгрөгийг, Ц. Бөхсумъяабазарт 336.0 мянган төгрөгийн

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

цалинг илүү тооцож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Алтай-Улиастайн ЭХС ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/65 дугаартай "Компанийн ажилтнуудын цалин хөлс тогтоох журам" тушаалын заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалин 1,280.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

2. Тайшир Гуулин УЦС ХХК нь сахилгын шийтгэлтэй 1 ажилтанд 12 сард 780.4 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Алтай-Улиастайн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын 2024 оны А/68 дугаар "Компанын дотоод журмыг шинэчлэн батлах тухай"-ын тушаалын хавсралтын 48 дугаар дугаар зүйлийн 48.5-д "сахилгын шийтгэлтэй ажилтанд тухайн тайлант хугацааны гүйцэтгэлийн үр дүнгийн бүх урамшууллыг олгохгүй", Тайшир Гуулин УЦС ХХК-ийн 2025 оны 12 сарын 31 өдрийн б/124 дүгээр "хариуцлага тооцох тухай" тушаалтай нийцэхгүй, эрх ба үүрэг, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалин 780.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

3. Завхан салбар нь албан хаагчийн удаан жилийн нэмэгдлийг тооцож олгохдоо 351.0 мянган төгрөгийг дутуу 130.5 мянган төгрөгийг илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, Алтай-Улиастайн ЭХС ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/65 дугаартай "Компанийн ажилтнуудын цалин хөлс тогтоох журам" тушаалтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу олгосон цалинг ажилтанд нөхөн олгож, илүү олгосныг орон нутгийн төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Ажиллагсад 12 сард 10,916.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад", Алтай-Улиастайн ЭХС ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/65 дугаартай "Компанийн ажилтнуудын цалин хөлс тогтоох журам" тушаалтай нийцэхгүй үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Тосонцэнгэл УЦС ХХК нь ажиллагсад 2,400.0 мянган төгрөгийн шагнал урамшуулал олгохдоо 240.0 мянган хувь хүний орлогын албан татвар суутган тооцоогүй олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах",

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх", 26 дугаар зүйлийн 26.1-т "Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу албан татвар ногдуулах орлогоо өөрөө үнэн зөв тодорхойлж, доор дурдсан хугацаанд албан татварыг холбогдох төсөвт төлнө"-тай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Богдын голын УЦС ХХК нь өндөр насны тэтгэвэрт гарсан 1 албан хаагчийн тэтгэмжийг олгохдоо 1,331.6 мянган төгрөгийг илүү тооцож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; "Алтай-улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны 2025-2026 оны хамтын гэрээний 5.11-т " Эрчим хүчний салбарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмадуудад салбарт ажилласан жил тутамд эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр бодож нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгоно. Тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн ажилтан өөрийн хүсэлтээр үргэлжлүүлэн ажилласан тохиолдолд зөвхөн үндсэн цалингаар цалинжуулна, нэмэгдэл хөлс авахгүй." 5.13-т "Эрчим хүчний салбарт ажиллаж байгаад үйлдвэрлэлийн осол, мэргэшлийн өвчнөөс шалгаалсны улмаас группэд байгаа иргэдээс өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон тохиолдолд эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тухайн байгууллагад ажилласан жилээр үржүүлж нэг удаа тэтгэмж олгоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. Завхан салбар нь тайланд онд иргэн, аж ахуй нэгж байгууллагатай 10 ажил гүйцэтгэх гэрээг 66,186.0 мянган төгрөгөөр байгуулсан боловч гэрээнд ажлын нэр, тоо хэмжээ тусгаагүй, тодорхойгүй, ажлын даалгаваргүй, гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, хүлээн авсан актгүй, тайлан илтгэх хуудасгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5. Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК нь Блейк стар альфа, Бизлис визард, Майнример, Огмент, Энхансмент ХХК-иуд руу тус бүр 19,960.0 мянган төгрөг, нийт 99,800.0 мянган төгрөгийг олон нийтэд эрчим хүчний үнэ салбарын мэдээллийг олон нийтэд сурталчлах зорилгоор шилжүүлж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй арга хэмжээнд хөрөнгө зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион

байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод аудиторт хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Баталсан зорилтот түвшний биелэлттэй холбоотой

Илрүүлэлт: Тайшир Гуулин УЦС ХХК нь батлагдсан зорилтот түвшинд тусгасан бусад орлого 6,410.9 мянган төгрөгөөр тасарсан ба зардлыг 115,141.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 13 дугаар "Компанийн 2025 оны техnid, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тогтоолтой нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан зорилтот түвшний биелэлтийг хангуулж ажиллах.

Хоёр. Цалин, хөлсний зардалтай холбоотой

Илрүүлэлт: Завхан салбар нь бүтцийн өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөгдсөн 18 ажилтны ээлжийн амралтын дуусгалтын тооцооны хугацааг буруу тооцож амралтын дуусгалтын мөнгийг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.3-т "Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралт "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2.8-т "Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох үед ажил олгогч нь ажилтантай ээлжийн амралтын тооцоог дараах байдлаар хийнэ. Үүнд: ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн амралтын цалинг олгох; ажилтнаас илүү олгосон ээлжийн амралтын цалингийн суутгалыг хийх" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилтны дуусгалтын тооцоог холбогдох журмын дагуу үнэн зөв тооцоолж, олгож байх.

Гурав. Баталсан орон тоо бүтэцтэй холбоотой

Илрүүлэлт: Тайшир Гуулин УЦС ХХК нь баталсан орон тоонд тусгаагүй 2 гэрээт ажилтан авч ажиллуулан 40,720.5 мянган төгрөгийн цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-д "тухайн үйлдвэрийн газрыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх, итгэмжлэл олгох", 20.1.2-т "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", 20.1.4-т үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Баталсан бүтэц орон тоог баримталж ажиллах.

Дөрөв. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой

Илрүүлэлт: Тосонцэнгэл УЦС ХХК нь жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор шатахуун 5,303.1 мянган төгрөгөөр дутагдсан боловч үр дүнг шийдвэрлээгүй, нягтлан бодогч, тооцоог бодоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", "12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жилийн эцсийн тооллогын үр дүнгээр тооцоо бодож байх.

Тав. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Завхан салбар нь Төрийн хэмнэлтийн хууль зөрчин гүйцэтгэх захирлын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн Б/36 дугаар тушаалаар 5,895.0 мянган төгрөгийн шагналыг 14 албан хаагчдад олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжид зааснаас бусад хэлбэрээр шагнал, урамшуулал олгохгүй байх.

Зургаа. Цалин, хөлсний зардалтай холбоотой

Илрүүлэлт: Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК нь албан хаагчдад 2 дугаар сард 9,495.0 мянган төгрөгийн цалингийн нэмэгдлийг гүйцэтгэх захирлын тушаалаар илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Төрийн хэмнэлтийн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжид зааснаас бусад хэлбэрээр дэмжлэг олгохгүй байх.

Долоо. Цалин, хөлсний зардалтай холбоотой

Илрүүлэлт: Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК нь орон тооны цомхотголд орсон 1 албан хаагчид 36,955.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон боловч, шинэ бүтцээр тус орон тоог баталсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Төрийн хэмнэлтийн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжид зааснаас бусад хэлбэрээр тэтгэмж олгохгүй байх.

Найм. Цахим худалдан авалттай холбоотой

Илрүүлэлт: Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК нь тайлант онд 2 удаа шууд гэрээ байгуулан нийт дүнгээр 33,500.0 мянган төгрөгийн компьютер, принтер худалдан авсан бөгөөд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, цахимаас худалдан аваагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил,

үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цахим дэлгүүрт байршсан бараа, ажил, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахгүй байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Запруулсан		Запруулаагүй		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК	Тосонцэнгэл УЦС ХХК 18,709.9 мянган төгрөгөөр, Богдын голын УЦС 1,674.9 мянган төгрөгөөр мөнгөн гүйлээний тайлангийн орлогыг зөрүүтэй тайлагнасан, Тосонцэнгэл УЦС ХХК 17,440.4 мянган төгрөгөөр мөнгөн гүйлээний тайлангийн зардлыг зөрүүтэй тайлагнасан	1	17,440.4	-	-	1	17,440.4	1	17,440.4	-	-	-	-
	Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК 466,578.6 мянган төгрөгөөр орлого үр дүнгийн тайлангийн борлуулалтын орлогыг зөрүүтэй тайлагнасан	1	466,578.6	-	-	1	466,578.6	1	466,578.6	-	-	-	-
	Богдын голын УЦС ХХК 1,211.4 мянган төгрөгөөр орлого үр дүнгийн тайлангийн зардлыг зөрүүтэй тайлагнасан	1	1,211.4	-	-	1	1,211.4	1	1,211.4	-	-	-	-
	Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК 119,985.2 мянган төгрөгийн шилжүүлсэн бараа материалыг бусад ангилалд тайлагнасан	1	119,985.2	-	-	1	119,985.2	1	119,985.2	-	-	-	-
	Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК 109,669.3 мянган төгрөгийн богино хугацаат өр төлбөрийг илүү тайлагнасан	1	109,669.3	-	-	1	109,669.3	1	109,669.3	-	-	-	-

Шилэн дансны цахим системд мэдээллийг оруулаагүй.	3	4,305,401.5	3	4,305,401.5	-	-	-	-	-	-
Дүн	10	5,040,671.2	3	4,305,401.5	7	735,269.70	7	735,269.70	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Үүнээс									
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК	Батлагдсан зорилтот түвшин ханган ажиллаагүй.	1	121,551.9	-	-	-	-	1	121,551.99	-	-
	Ажиллагчдад төлсөн зардлаас албан хаагчдад цалин хөлс илүү, дутуу олгосон.	5	13,698.5	3	2,542.4	2	11,156.1	-	-	-	-
	Бүтцийн өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн ээлжийн амралтын дуусгалтын тооцооны хугацааг буруу тооцсон	1	-	-	-	-	-	-	1	-	-
	Баталсан орон тоонд тусгаагүй гэрээт ажилтан авч ажиллуулан цалин олгож төсвийн арвилан хэмнэлттэй зарцуулсан.	1	40,720.5	-	-	-	-	-	1	40,720.5	-
	Өндөр насны тэтгэвэрт гарсан албан хаагчийн тэтгэмжийг олгоходоо илүү, дутуу тооцож олгосон.	1	1,331.6	-	-	1	1,331.6	-	-	-	-
Жилийн эцсийн хөрөнгийн тооллогын үр дүнг шийдвэрлээгүй, нягтлан бодогч, тооцоог бодоогүй.	1	5,303.1	-	-	-	-	-	1	5,303.1	-	
Төрийн хэмнэлтийн хууль зөрчин албан хаагчдад шагнал, тэтгэмж, бусад зардалд зарцуулсан.	3	52,345.0	-	-	-	-	-	3	52,345.0	-	
Тайланд онд иргэн, аж ахуй нэгж байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй, байгуулсан гэрээнд ажлын нэр, тоо хэмжээ тусгаагүй, тодорхойгүй, ажлын даалгаваргүй, гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, хүлээн авсан актгүй, тайлан илтгэх хуудасгүй байна.	1	68,186.0	-	-	1	68,186.0	-	-	-	-	



	Олон нийтэд эрчим хүчний үнэ салбарын мэдээллийг олон нийтэд сурталчлах зорилгоор шилжүүлж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй арга хэмжээнд хөрөнгө зарцуулсан байна.	1	99,800.0	-	-	1	99,800.0	-	-
	Компьютер, принтер худалдан авсан бөгөөд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, цахимаас худалдан аваагүй байна.	1	33,500.0	-	-	-	-	1	33,500.0
Дүн		16	436,437.0	3	2,542.4	5	180,474.0	8	253,421.6

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгаасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
		3	4	5	6	7	8	9	10	11	12
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК	Тайлант онд компанийн зардлын төлөвлөгөөнд туссан бараа ажил үйлчилгээ худалдан авах босго үнээс давсан худалдан авалт хийхдээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй. Ашиг сонирхлын зөрчилтэй этгээдтэй гэрээ байгуулсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй төсөл арга хэмжээнд хөрөнгө оруулалтын зардал гаргасан байна. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлгүй этгээдээс 5 удаагийн шууд гэрээ байгуулж, хөрөнгө бэлтгэсэн байна. Компанийн худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд 64 ажлыг 8,921,611.0 мянган төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан боловч гүйцэтгэлээр 58 ажлыг	5	356,934.8	-	-	-	-	5	356,934.8	-	-
		1	19,900.0	-	-	1	19,900.0	-	-	-	-
		1	83,162.2	-	-	-	-	1	83,162.2	-	-
		1	83,980.5	-	-	-	-	1	83,980.5	-	-
		1	-	-	-	-	-	1	-	-	-





ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

20 26 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 01/60

A0760260

Алтай хот

ГАА - 2026 / 0021 КА - СА - ТУЧ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Сахилгын шийтгэлтэй 1 ажилтанд 12 дугаар сард 780,400 (Долоон зуун наян мянган дөрвөн зуу) төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-д "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Алтай-Улиастайн эрчим хүчний систем төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлын 2024 оны А/68 дугаар "Компанийн дотоод журмыг шинэчлэн батлах тухай"-ын тушаалын хавсралтын 48 дугаар дугаар зүйлийн 48.5-д "сахилгын шийтгэлтэй ажилтанд тухайн тайлант хугацааны гүйцэтгэлийн үр дүнгийн бүх урамшууллыг олгохгүй", Тайшир Гуулин УЦС ХХК-ийн захирлын "Хариуцлага тооцох тухай" 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Б/124 дугаар тушаалтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

- Илүү олгосон 780,400 (Долоон зуун наян мянган дөрвөн зуу) төгрөгийг Төрийн сан дахь Га.Аудитын орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх.
- Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг "Тайшир ногоон эрчим" ХК-ийн гүйцэтгэх захирал (Д.Амартүвшин), нягтлан бодогч (Г.Ганчимэг) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Г.ГҮНЖИДМАА

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Д.ЦЭРЭНХАНД

¹ Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Жинст баг Хөгжил хороолол 1402 тоот. Утас 70484030

822511000210



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 02/60

А0760260 Алтай хот

ГАА - 2026 / 002 / КА - СТА - ТӨЧ
ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Цагийн бүртгэлийг зөрүүтэй хөтөлснөөс 12 дугаар сард Б.Түвшинжаргалд 944,500 (Есөн зуун дөчин дөрвөн мянга таван зуу) төгрөгийг, Ц.Бөхсумъяабазарт 336,000 (Гурван зуун гучин зургаан мянга) төгрөгийн цалинг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/65 дугаар тушаалаар баталсан "Компанийн ажилтнуудын цалин хөлс тогтоох журам"-тай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

- Илүү олгосон 1,280,500 (Нэг сая хоёр зуун наян мянга таван зуу) төгрөгийг Төрийн сан дахь Га.Аудитын орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх.
- Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Тайшир ногоон эрчим ХК-ийн гүйцэтгэх захирал (Д.Амартүвшин), нягтлан бодогч (Г.Ганчимэг) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Г.ГҮНЖИДМАА
Д.ЭРДЭНЭЧИМЭГ
Д.ЦЭРЭНХАНД

¹ Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Жинст баг Хөгжил хороолол 1402 тоот. Утас 70484030

822511000213



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

20 26 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 03/60

А077-0262

Алтай хот

ГНА - 2026 / 002 / КА - СА - 004Г
ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Алтай-Улиастай эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Ажилчдад удаан жилийн нэмэгдлийг тооцож олгохдоо 351,025 (Гурван зуун таван нэгэн мянга хорин таван) төгрөгийг дутуу, 130,587 (Нэг зуун гучин мянга таван зуун наян долоо) төгрөгийг илүү олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-т "Үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", Хамтын гэрээний 3 дугаар зүйлийн 3.12-т Эрчим хүчний салбарт ажиллаж байгаа ажилтанд удаан жил ажилласны нэмэгдлийг тус салбарт ажилласан хугацаанаас хамааруулан хөдөлмөрийн хэвийн нөхцөлд албан тушаалын болон үндсэн цалингийн 35 хүртэлх, хэвийн бус нөхцөлд албан тушаалын болон үндсэн цалингийн 40.0 хүртэлх хувиар бодож олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажилчдад дутуу олгосон 351,025 (Гурван зуун хорин таван мянга хорин таван) төгрөгийг нөхөн олгох, илүү олгосон 130,587 (Нэг зуун гучин мянга таван зуун наян долоо) төгрөгийг Төрийн сан дахь Га.Аудитын орлогын 100050000982 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Алтай-Улиастайн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Завхан аймаг дахь салбарын дарга (Г.Бадамхатан), нягтлан бодогч (Д.Жаргалтуяа) нарт хариуцуулав

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА
Д.ЭРДЭНЭЧИМЭГ
Д.ЦЭРЭНХАНД
М.АТАРЦЭЦЭГ

¹ Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Жинст баг Хөгжил хөрөөлөл 1402 тоот. Утас 70484030

822511000215



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 04/68

A0770262

Алтай хот

ГАН - 2026 / 002 / КА - СНА - ТӨЧГ
ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Алтай-Улиастайн Эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тайлант онд иргэн, аж ахуй нэгж, байгууллагатай ажил гүйцэтгэх 10 гэрээг 68,186,000 (Жаран найман сая нэг зуун наян зургаан мянга) төгрөгөөр байгуулсан боловч гэрээнд ажлын нэр, тоо хэмжээг тусгаагүй, тодорхойгүй, ажлын даалгаваргүй, гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, хүлээн авсан акт, тайлан илтгэх хуудасгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Ажил гүйцэтгэх 10 гэрээг дүгнээгүй, хүлээн аваагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх.
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтай Улиастайн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Завхан аймаг дахь салбарын дарга (Г.Бадамхатан), нягтлан бодогч (Д.Жаргалтуяа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Т.ГҮНЖИДМАА

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Д.ЦЭРЭНХАНД

М.АТАРЦЭЦЭГ

¹ Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Жинст баг Хөгжил хороолол 1402 тоот. Утас 70484030

822503000328



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

20 26 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 01/68

AD760260

Алтай хот

ГАА - 2025 / 002 / КА - СТА - 1041

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Блейк стар альфа ХХК, Бизлис визард ХХК, Майнримек ХХК, Огмент ХХК, Энхансмент ХХК-д тус бүр 19,960,000 (Арван есөн сая есөн зуун жаран мянга) төгрөг, нийт 99,800,000 (Ерэн есөн сая найман зуун мянга) төгрөгийг олон нийтэд эрчим хүчний үнэ, салбарын мэдээллийг сурталчлах ажлын төлбөрт шилжүүлсэн байна.

Дээрх төсөл, арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, төсөвт өртгийг хувааж шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн 17 дугаар тогтоол "Компанийн худалдан авах ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй төсөл, арга хэмжээнд хөрөнгө зарцуулсан асуудалд дотоод хяналт хэрэгжүүлж, үр дүнг тооцон биелэлтийг 2026 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтай улиастайн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн дотоод аудитор (Д.Нарантуяа)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Г.ГҮНЖИДМАА

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Д.ЦЭРЭНХАНД

¹ Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Жинст баг Хөгжил хороолол 1402 тоот. Утас 70484030

822509000304



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

20 26 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 08/68

А0770260

Алтай хот

ГАА - 2026 / 002 / ИА - СТА - ТӨЧГ
ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Компанийн Олон нийт хэвлэл мэдээллийн ажилтны нэр дээр бүртгэлтэй Миний-Алтай ХХК-тай гэрээ байгуулж, тайлант онд 19,900,000 (Арван есөн сая есөн зуун мянга) төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Хамаарал бүхий болон болохуйц этгээдтэй гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлж буй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх.
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтай-Улиастайн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Цэдэвсүрэн), нягтлан бодогч (Г.Идэрхангай) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА
Д.ЭРДЭНЭЧИМЭГ
Д.ЦЭРЭНХАНД

¹ Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Жинст баг Хөгжил хороолол 1402 тоот. Утас 70484030

822509000345



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 02/68

AD760260

Алтай хот

ГАА - 2026 / 002 / ИА - СА - ТӨЧГ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Ажиллагсад тайлант оны 12 дугаар сард 10,916,100 (Арван сая есөн зуун арван зургаан мянга нэг зуу) төгрөгийн үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "Хуулиар зөвшөөрөөгүй бусад", Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/65 дугаар тушаалаар баталсан "Компанийн ажилтнуудын цалин хөлс тогтоох журам" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгож байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тайшир ногоон эрчим ХК-ийн гүйцэтгэх захирал (Д.Амартүвшин), нягтлан бодогч (Г.Ганчимэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Д.ЦЭРЭНХАНД

¹ Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Жинст баг Хөгжил хороолол 1402 тоот. Утас 70484030

822509000324



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 06/68

AD760261

Алтай хот

ГАА - 2026 / 002 / ИА - ГА - ТУУ
ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Өндөр насны тэтгэвэрт гарсан 1 албан хаагчийн тэтгэмжийг олгоходоо 1,331,600 (нэг сая гурван зуун гучин нэгэн мянга зургаан зуу) төгрөгийг илүү тооцож олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хорооны 2025-2026 оны хамтын гэрээний 5.11-т "Эрчим хүчний салбарт ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмадуудад салбарт ажилласан жил тутамд эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр бодож нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгоно. Тэтгэвэр тогтоолгох эрх үүссэн ажилтан өөрийн хүсэлтээр үргэлжлүүлэн ажилласан тохиолдолд зөвхөн үндсэн цалингаар цалинжуулна, нэмэгдэл хөлс авахгүй", 5.13-т "Эрчим хүчний салбарт ажиллаж байгаад ҮО, МШӨ-ийн улмаас группэд байгаа иргэдээс өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон тохиолдолд эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тухайн байгууллагад ажилласан жилээр үржүүлж нэг удаа тэтгэмж олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Тэтгэмжийн тооцооллыг дахин хийж зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх.
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тайшир ногоон эрчим ТӨХК-ийн Завхан аймаг дахь салбарын дарга (Д.Баярмагнай), нягтлан бодогч (Б.Сэвжидмаа) нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Г.ГҮНЖИДМАА
Д.ЭРДЭНЭЧИМЭГ
Б.ЦЭЦЭГМАА

¹ Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Жинст баг Хөгжил хороолол 1402 тоот. Утас 70484030

822509000348

822509000348



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

20 26 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 05/68

А0760261

Алтай хот

ГАА - 2026 / 0021 НА - СТА - ТӨЧГ
ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Алтай-Улиастайн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Ажиллагсад 2,400,000 (хоёр сая дөрвөн зуун мянга) төгрөгийн шагнал урамшуулал олгохдоо 240,000 (хоёр зуун дөчин мянга) төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутган тооцоогүй олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх", 26 дугаар зүйлийн 26.1-т "Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу албан татвар ногдуулах орлогоо өөрөө үнэн зөв тодорхойлж, доор дурдсан хугацаанд албан татварыг холбогдох төсөвт төлнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Суутган тооцоогүй татварын тооцоог хийж, татварын тайланд залруулга хийн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтай-Улиастайн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Завхан дахь салбарын дарга (Г.Бадамхатан) нягтлан бодогч (Д.Жаргалтуяа) нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Г.ГҮНЖИДМАА

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Б.ЦЭЦЭГМАА

8217144139

¹ Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Жинст баг Хөгжил хороолол 1402 тоот. Утас 70484030

822509000331